

БАТЛАВ.
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

ЗӨВШӨӨРӨВ.
“.....” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.БИЛГҮҮН

.....

ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЭЭ

202.. оны .. сарын .. -ны өдөр

Дугаар /.....

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн нэг талаас Стандарт, хэмжил зүйн газрыг төлөөлж Итгэмжлэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Соронзонболд (цаашид гүйцэтгэгч гэх), нөгөө талаас “.....” ХХК-ийг төлөөлж /ТҮБ-ын дарга, албан тушаал/...../овог нэр/ (цаашид захиалагч гэх) бид дараах нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гүйцэтгэгч байгууллагын эрх, үүрэг

- 1.1. Тохирлын үнэлгээний байгууллагын чадавхийн үнэлгээг хараат бус, шударга, үл ялгаварлах хандлагагүйгээр мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх;
- 1.2. Гэрээнд заагдсан ажлуудыг биелүүлэхтэй холбогдсон нийтлэг асуудлаар арга зүйн зөвлөмж өгөх, хяналт тавих, сургалт явуулах;
- 1.3. Итгэмжлэлийн шаардлагын аливаа өөрчлөлтийн талаар тухай бүрд нь мэдээлэх;
- 1.4. Итгэмжлэлийн шаардлагад нийцээгүй үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдвол итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн хүрээг багасгах, итгэмжлэлийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх буюу хүчингүй болгох;
- 1.5. Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагын техник, технологи болон худалдааны нууцтай холбоотой мэдээллийн нууцыг хамгаалах;
- 1.6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дах хэсэгт заасны дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдэх, албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр гаргаж өгөх

Хоёр. Захиалагч байгууллагын эрх, үүрэг

- 2.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, тохирлын үнэлгээний байгууллагын чадавхид тавих холбогдох стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- 2.2. Шаардлагатай тохиолдолд итгэмжлэлийн шаардлагыг хангаж ажиллаж байгааг батлахын тулд итгэмжлэлийн газартай хамтран ажиллах;

2.3. Итгэмжлэлийн шаардлагыг хангаж ажиллаж байгааг батлахын тулд тохирлын үнэлгээний байгууллагын ажилтан, байрлал, тоног төхөөрөмж, мэдээлэл, баримт бичиг, бүртгэлтэй танилцах боломжоор хангах;

2.4. Итгэмжлэлийн байгууллагын шаардсанаар тохирлын үнэлгээний гэрчлэх үнэлгээг зохион байгуулах;

2.5. Тохирлын үнэлгээний байгууллагын хэрэглэгчийн байрлал дээр итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсэг ажиллах боломжоор хангах;

2.6. Итгэмжлэлийн таних тэмдэг, тэмдгийг зөвхөн итгэмжлэлийн хүрээнд гүйцэтгэсэн тохирлын үнэлгээний үр дүнг баталгаажуулахад хэрэглэх;

2.7. Итгэмжлэлийн таних тэмдгийг итгэмжлэлийн байгууллагаас баталсан журмын дагуу хэрэглэх;

2.8. Итгэмжлэлийн байгууллагыг үл хүндэтгэсэн байдлаар итгэмжлэлийг ашиглахгүй байх;

2.9. Итгэмжлэлд хамаарах эрх зүйн байдал, үйл ажиллагааны чухал ач холбогдол бүхий өөрчлөлтийн талаар цаг тухайд нь Итгэмжлэлийн газарт мэдэгдэх;

2.10. Итгэмжлэлийн болон магадлах шалгалтын ажилтай холбогдон гарах зардал, үнэлгээний ажлын хэсгийн унаа, байр, томилолтын зардлыг итгэмжлэлийн ажлын үр дүнгээс хамаарахгүйгээр хариуцан төлөх;

2.11. Тохирлын үнэлгээний байгууллагатай холбоотой аливаа гомдлыг шийдэх, шалгахад Итгэмжлэлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх;

2.12. Итгэмжлэлийн үнэлгээ явуулсан ажлын хэсэг, итгэмжлэлийн Техникийн хорооноос гарсан зөвлөмж, өгөгдсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлэх;

2.13. Дахин итгэмжлүүлэх тухай хүсэлтээ итгэмжлэлийн гэрчилгээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө гаргах;

2.14. Тохирлын үнэлгээний холбогдолтой олон улсын стандартыг орчуулах, стандарт боловсруулах, үндэсний стандартыг шинэчлэх ажилд идэвхи, санаачлагатай оролцох;

2.15. Тохирлын үнэлгээний үр дүнгийн үнэн зөв, нэгдмэл байдлыг хангах, түүнд хяналт тавих зорилгоор ур чадварын сорилт/лаборатори хоорондын харьцуулалтанд тогтмол оролцдог байх;

Гурав. Гэрээний төлбөр, хугацаа

3.1. Итгэмжлэлийн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах тухай Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тушаалыг үндэслэн итгэмжлэлийн ажил үйлчилгээний хураамжийг дараахь байдлаар төлнө. Үүнд:

3.1.1. Өргөдлийн хураамж төгрөг (Итгэмжлүүлэхээр хүсэлт гаргахад төлсөн байна)

3.1.2. Үнэлгээний хураамж төгрөг (Үнэлгээний ажлын хэсэг томилогдож үнэлгээ эхлэхийн өмнө төлсөн байна)

3.1.3. Жилийн хураамж төгрөг (Итгэмжлэлийн шийдвэрийг албажуулахын өмнө төлсөн байна)

3.2. Гэрээ нь итгэмжлэлийн гэрчилгээний хугацаанд хүчинтэй байна

Дөрөв. Бусад зүйл

4.1. Итгэмжлэлийн гэрчилгээ олгосноор итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагаанаас үүдэн хэрэглэгчид учирсан хохирлын хариуцлагыг гүйцэтгэгч хүлээхгүй.

4.2. Захиалагч тал нь итгэмжлэлтэй холбогдох зардлыг заасан хугацаанаас хойш 30 хоногийн дотор төлөөгүй бол итгэмжлэлийг цуцлах үндэслэл болно.

4.3. Итгэмжлэл, итгэмжлэгдсэн байгууллагын үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, итгэмжлэлийн байгууллага, итгэмжлэгдсэн байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр талууд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

4.4. Энэхүү гэрээ хоёр талын удирдлагууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

4.5. Гэрээг хоёр хувь үйлдэж, нэг хувийг гүйцэтгэгч, нөгөө хувийг захиалагч тал хадгална.

4.6. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хоёр тал тохиролцон шийдвэрлэнэ.

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:
Итгэмжлэлийн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Соронзонболд

Хянасан: Ерөнхий нягтлан бодогч

Т.Энхтүвшин

Хуулийн зөвлөх

Б.Эрхүү

Хаяг: Энх тайваны өргөн чөлөө-46

Улаанбаатар 210351

Харилцах утас: 263689

Данс: Төв төрийн сан банкны

100900009012 тоот данс

Регистрийн дугаар: 9096035

Захиалагч байгууллагыг төлөөлж:

ТҮБ-ын дарга /Албан тушаал/

..... /Овог, нэр/

Хянасан: Ерөнхий ня-бо

.....

Гэрээ эрх зүйн асуудал хариуцсан

мэргэжилтэн

.....

Хаяг:

.....

.....

.....

Харилцах утас:

Регистрийн дугаар:

Итгэмжлэлийн хөтөлбөр

№	Итгэмжлэлийн үнэлгээний төрөл	Огноо	Итгэмжлэлийн хүрээг хамруулсан байдал	Үнэлгээний хугацаа хүн/өдөр	Хариуцах ажилтны нэр
1	Анхдагч үнэлгээ		Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлт бүрээр		
2	Магадлах үнэлгээ		Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлтийн 50-иас доошгүй хувь		
3	Магадлах эсвэл давтан үнэлгээ		Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлтийн 50-иас доошгүй хувь эсвэл итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлт бүрээр		
	Магадлах үнэлгээ		Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлтийн 50-иас доошгүй хувь		
	Магадлах үнэлгээ		Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлтийн 50-иас доошгүй хувь		
4	Давтан үнэлгээ		Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлт бүрээр		

Тайлбар:

1. Эрсдэлээс шалтгаалан хамрах хүрээнээс сонгох байдлаар үнэлэх эсвэл зайнаас үнэлгээг хийж болно
2. Магадлах үнэлгээ давтан үнэлгээг хийх хугацааг итгэмжлэлийн шийдвэр гарсан хугацаатай уялдуулан тогтооно.
3. Магадлах үнэлгээний үед итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод орсон үзүүлэлтээс сонголт хийхдээ өмнөх магадлах үнэлгээнд хамрагдаагүй үзүүлэлтийг сонгоно.